

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар:</p> <p>Олон Улсын Хүүхдийн Найрамдал цогцолбор захиргааны байр</p>
ГЕН 2.6.	<p>Бараа нийлүүлэх хугацаа: 2024.04.20</p> <p><i>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа Нийлүүлэлтийн хуваарь баримтлах</i></p>
ГЕН 2.10.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p>[Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих]</p> <p>Бараанд холбогдох баримт бичиг: Холбогдох баримт бичиг техник ашиглалтын паспорт, техникийн тодорхойлолт зэрэг</p> <p>Угсралт, суурилуулах: Тухайн нийлүүлсэн барааг угсарч, ашиглалтын зааварчилгаа өгч хүлээлцэх</p>
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:</p> <p>Нийлүүлж буй бараа нь хайрцаг сав баглаа боодол бүхий лацтай байх.</p> <p>Барааны гэрчилгээ, болон үйлдвэрлэгч газрын танилцуулга</p> <p>Баглаа, боодлын шаардлага:</p> <p>Жишээ нь:</p> <p>[Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]</p>
ГЕН 2.17.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p>Incoterms 2020, DDP, Барааг ОУХ"Найрамдал" цогцолбор Захиргааны байр 209 тоот</p>
ГЕН 3.8.	<p>Үнийн тохируулга хийх аргачлал:</p> <p>"Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томъёог ашиглан тохируулна:</p> $\Delta P = P_0 (a + b \frac{L_1}{L_0} + c \frac{M_1}{M_0}) - P_0$ <p style="text-align: center;">$L_0 \quad M_0$</p> <p>Үүнд:</p> <p>ΔP -нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ</p>

	<p><i>P₀-гэрээний үндсэн үнэ;</i></p> <p><i>a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;</i></p> <p><i>b -гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;</i></p> <p><i>c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;</i></p> <p><i>L₀-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;</i></p> <p><i>L₀, L₁ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;</i></p> <p><i>M₁, M₀ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.</i></p> <p><i>[захиалагч a, b, c илтгэлцүүрүүдийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Энэ гурван итгэлцүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.]</i></p> <p><i>Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.</i></p> <p><i>Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.</i></p> <p><i>Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих]¹ долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).</i></p> <p><i>Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд үнийг тохируулах санал гаргах эрхтэй. Үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> <i>1. Гэрээний суурь үнэ [тоо бичих]² хувиас илүү өсөх, эсхүл буурахаар бол үнийг тохируулна.</i> <i>2. Гэрээг сунгах албан бичигт онцгойлон өөрөөр заагаагүй бол барааг нийлүүлэх анхны хуваариас хоцорч нийлүүлсэн хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Нийлүүлэгчээс шалтгаалан хоцорсон хугацаанд үнийн тохируулга хийхгүй. Гэхдээ гэрээний үнэ буурах үнийн тохируулгыг захиалагч эдгээр хугацаанд хийж болно.</i> <p><i>Гэрээний үнийн /P₀/ валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, залруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна.</i></p>
ГЕН 3.9.	<p><i>Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр]</i></p> <p><i>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]</i></p>

¹Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.

²Арван таван (15) хувийг зүй зохистой хэмжээ гэж үзнэ.

ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p><i>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]</i></p>
ГЕН 4.10.	<p>Баталгаат хугацаа:</p> <p><i>Баталгаат хугацаа 1 жил</i></p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: <i>шаардана</i></p> <p><i>Чанарын баталгаа шаардах бол,</i></p> <p>Чанарын баталгааны дүн: <i>5 хувь</i></p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: <i>“Тийм”</i>,</p> <p>Алдангийн хувь: <i>хоног тутамд 0.5 хувь</i></p>
ГЕН 4.18.	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: <i>“Үгүй”</i></p> <p>Алдангийн хувь: <i>хоног тутамд 0.5 хувиар</i></p>